



НӨАТ-ын буцаан олголтын урамшуулал авах иргэдийн анхааралд!

2016 оны НӨАТ-ын буцаан олголтын урамшуулал олгоход иргэн таны мэдээлэл ebarimt.mn цахим хуудсанд бүрэн гүйцэд бүртгэгдсэн байх шаардлагатай. Иймд иргэн Та буцаан олголт авах дансны мэдээллээ **ebarimt.mn цахим хуудас руу орж шалгаарай.**

НЭГ. Таны мэдээлэл бүрэн баталгаажсан бол цахим хуудас руу нэвтрэн ороход доорх “Мэдээлэл” сануулга гарч ирнэ. Энэ тохиолдолд таны мэдээлэл үнэн зөв баталгаажсан бөгөөд урамшуулал авахад бэлтгэл хангагдсан гэж ойлгоно.



ХОЁР. Харин ebarimt.mn цахим хуудас руу нэвтрэн ороход доорх “Анхааруулга” сануулгууд гарч ирсэн тохиолдолд таны мэдээлэл үнэн зөв баталгаажаагүй, урамшуулал авах бэлтгэл хангагдаагүй байгаа бөгөөд та мэдээллээ үнэн зөв оруулах шаардлагатай.



ГУРАВ. Та мэдээллээ үнэн зөв оруулахын тулд:

ЕВАРИМТ.МН → **ХУВЬ ХҮН / НЭВТРЭХ** → **ДАНС ТОХИРУУЛАХ**

/Та код, нууц үгээ мартсан бол: ХУВЬ ХҮН / НЭВТРЭХ → “Бүртгэлээ сэргээх бол **ЭНД** дарна уу!”/
дарааллаар орж, доорх байдлаар мэдээллээ үнэн зөв болгоно уу. **Жишээ загвар:**

EVarimt.mn ДАНС ТОХИРУУЛАХ ХЭСЭГТ	Жишээ нь:
	Овог: <input type="text" value="Бат"/> <i>Анхаарах: Монгол кирилл үсгээр бичих</i>
	Нэр: <input type="text" value="Болд"/> <i>Анхаарах: Монгол кирилл үсгээр бичих</i>
	Утас: <input type="text" value="88878685"/> <i>Анхаарах: 8 оронтой өөрийн нэр дээр бүртгэлтэй</i>
Зай авахгүй, Монгол кирилл үсгээр бичих	Регистер: <input type="text" value="ХМ85123008"/> <i>Анхаарах: Монгол кирилл үсгээр бичих</i>
Картын дугаар биш, ДАНС-ны Дугаар бичих	Банк: <input type="text" value="Төрийн банк"/> <i>Анхаарах: Банкны мэдээлэл зөрөхгүй байх</i>
	Данс: <input type="text" value="1926101632"/> <i>Анхаарах: 1. Хамтран эзэмшигчгүй байх 2. Идэвхтэй данс байх 3. Картын дугаар биш банкны данс байх</i>

Та гар утаснаасаа **131313 тусгай дугаарт** мессеж илгээж төлбөрийн баримтаа бүртгүүлдэг бол ebarimt.mn цахим хуудас руу хандан НӨАТ-ын буцаан олголтын урамшуулал авах иргэний овог, нэр, регистрийн дугаар, банкны нэр, дансны дугаараа заавал нягталж шалгана уу.

ebarimt.mn цахим хуудсанд нэвтрэх нэр болон нууц үгээ мэдэхгүй бол зөвхөн баримт бүртгүүлдэг гар утасныхаа дугаараас “?” гэж бичээд **131313** дугаарт мессеж илгээж авна уу.

ДӨРӨВ. Иргэн Та ebarimt.mn цахим хуудас руу хандах, интернэтэд холбогдох боломжгүй бол:

- ✓ Татварын албаны 1800-1288 лавлах утсанд хандаж бүртгүүлэх;
- ✓ Татварын байгууллагад биечлэн очиж бүртгүүлэх боломжтой.

Татварын ерөнхий газар

2017.01.17